



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН



ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Зургийн жагсаалт	4
Графикийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт	5
1. Удиртгал	6
2. Үнэлгээний арга зүй	6
2.1. Зорилго, зорилт	6
2.2. Хамрах хүрээ, аргачлал	7
2.3. Мэдээллийн сан бүрдүүлэлт ба ашиглалт	11
3. Үнэлгээний үр дүн	11
3.1. Олон нийттэй харилцах мэдээлэл сурталчилгааны ажил	13
3.2. Үйлчилгээний чанартай байдал	17
3.3. Үйлчилгээний хүртээмжтэй байдал	21
3.4. Үйлчилгээний хүнд сурталгүй шуурхай байдал	22
3.5. Үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал	24
4. Зөвлөмжийн биелэлт.....	26
5. Дүгнэлт.....	29
6. Санал зөвлөмж	30
7. Хавсралт материалууд	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Судалгаанд хамрагдсан иргэн, алба хаагчдын байршил, тоо, түүвэрлэлт
- Зураг 2. Судалгаанд хамрагдсан иргэн, алба хаагчдын хүйсийн харьцаа
- Зураг 3. Хуулийн онцлог, шинж байдал
- Зураг 4. Байгууллагын ил тод байдлыг үнэлсэн шалгуур үзүүлэлтийн дүрслэл
- Зураг 5. Ил тод байдлын үнэлгээ /shilen.gov.mn/
- Зураг 6. Иргэдэд хэрэгцээтэй мэдээллийн байдал
- Зураг 7. Шинжилгээ өгөхөд хариу нь үнэн зөв гарна гэж итгэдэг байдал, хувиар
- Зураг 8. Үйл ажиллагааны чанарын өөрчлөлтийг үнэлсэн байдал
- Зураг 9. Шаардлагатай тохиолдолд Шүүх шинжилгээний байгууллагын ажилтнууд шуурхай ажиллана гэдэгт итгэдэг байдал, хувиар
- Зураг 10. Байгууллагын албан хаагч албаны нэрээр далайлган сүрдүүлэх, зүй бус харилцах тохиолдол гарсан уу? Хувиар
- Зураг 11. Шүүх шинжилгээний үүсэл хөгжил, чиг хандлага

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал
- График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал
- График 3. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал
- График 4. Үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байдал
- График 5. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар
- График 6. Шаардлагатай үйлчилгээ үзүүлж чадсан эсэх, хувиар
- График 7. Одоогийн үйлчилгээг бүрэн авч чадсан байдал, хувиар
- График 8. Авч буй төлбөр хураамжийг үнэлсэн үнэлгээ
- График 9. Шаардлагатай үйлчилгээ үзүүлж чадсан эсэх, хувиар
- График 10. Үйлчилгээ авахад зориулж буй хугацаа болон шат дамжлагатай байдал
- График 11. Үйлчилгээний чанар, үнэн бодит байдлыг үнэлж буй иргэдийн үнэлгээ, 1 - 5 дунджаар
- График 12. Одоогийн авч байгаа үйлчилгээтэй холбоотой ямар нэгэн санал гомдол байгаа эсэх.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон аргачлал
- Хүснэгт 2. Үйлчилгээний чанартай байдалд өгсөн иргэдийн үнэлгээ, 1-5 онооны дунджаар
- Хүснэгт 3. Үйлчилгээний хүртээмжтэй байдлын үнэлгээ, 1-5 онооны дунджаар

1.УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Хууль зүй, дотоод хэргийн яам, харьяа агентлаг, байгууллага нь чиг үүргийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Их Хурлаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж мөрдүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газраас хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийнн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулан журамласан.

Журамд төрийн захиргааны байгууллагууд жил бүр үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл хамнамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тусгасан нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын нэгэн адил сайн засаглал, хариуцлага, ил тод байдал, хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох талаар оролцогч талуудаас тавьж буй шахалт шаардлагад мэдрэмжтэй хандах болсны тод илрэл юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгохыг заасан.

Иймд Шүүхийн шинжилгээний байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд зөвлөмж гарган ажиллалаа.

2.ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Зорилго, зорилт

Үнэлгээний зорилго: ШШЕГ-аас хэрэгжүүлж байгаа үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх, үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, чанартай, хүний эрхийг хүндэтгэсэн, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, үйлчилгээ авагчдын сэтгэл ханамж, хандлагыг судлах.

Зорилтот бүтээгдэхүүн:

1. Судалгааны ажлын тайлан, зөвлөмж гарсан байх;
2. Судалгааны анхдагч, хоёрдогч эх үүсвэр, баримт бичиг, материалууд;
3. Судалгааны тайлангийн хураангуйг Power point болон бусад программыг ашиглан бэлтгэгдсэн байх;

4. Судалгааны үр дүнгийн талаар Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлан хүргэгдсэн байх;

5. Шүүх шинжилгээний байгууллагаас олон нийттэй харилцах чиглэлээр явуулж буй мэдээлэл, сурталчилгааны ажлын үр дүн, үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт гарсан байх.

Хамрах хүрээ, аргачлал

Үнэлгээнд Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид болон үйлчлүүлэгч иргэдийг хамруулсан. Энэхүү судалгаагаар ШШБ-т хамаарах шалгуур үзүүлэлтийн дагуу тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хамаарах үнэлгээний мэдээлэл цуглуулсан.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан иргэн, алба хаагчдын байршил, тоо, түүвэрлэлт


АЛБА ХААГЧИД - УЛСЫН ХЭМЖЭЭНД: /Нийт 139 хүн хамрагдсан/

Нийслэлийн шүүх шинжилгээний алба болон орон нутгийн шүүх шинжилгээний хэлтсийн алба хаагчид



Тус судалгаагаар нийт 247 алба хаагчид болон иргэдийг хамруулсан. Үүнд: Эрэгтэй 146 буюу 59.1 хувь, эмэгтэй 101 буюу 40.9 хувь тус тус эзэлж байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан иргэн, алба хаагчдын хүйсийн харьцаа



Судалгаанд оролцогч нийт 247 хүний насыг ангилан авч үзвэл 24 наснаас доош ангилалд хамаарах 5, 25-34 насны ангилалд хамаарах 79, 35-44 насны ангилалд хамаарах 88, 45-54 насны ангилалд хамаарах 67, 55 наснаас дээш насны ангилалд хамаарах 8 хүн тус тус байна.

График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал



Боловсролын байдлыг нь авч үзвэл нийт оролцогчдын 35 хувь нь дээд, 20 хувь нь бүрэн дунд, 16.7 хувь нь бүрэн бус дунд, 15 хувь нь бага, 13.3 хувь нь боловсролгүй оролцогчид байв.

График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал



Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 67 нь буюу 34.1 хувь нь төрийн байгууллагад ажилладаг, 60 нь буюу 33.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 43 нь буюу 16.2 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 22 нь буюу 5 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг, 10 нь буюу 5.7 хувь нь оюутан, 9 нь буюу 1.8 хувь нь олон улсын байгууллагад ажилладаг, 6 нь буюу 1.2 хувь нь тэтгэвэрт гэсэн байдалтай байна.

График 3. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал



Үнэлгээний нарийвчилсан шалгуур үзүүлэлт болон тухайн үзүүлэлтийг тодорхойлоход

ашигласан судалгааны аргыг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон аргачлал

Шалгуур үзүүлэлт	Хэмжүүр	Судалгааны арга
Үйлчилгээний хүртээмжтэй байдал	<ul style="list-style-type: none"> - Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээ авах боломж, нөхцөл /интернет, утас, ТУЦ машинаар үйлчилгээ явагддаг эсэх, үйлчилгээний байгууллагын цагийн хуваарь гэх мэт/ - Үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал - Үйлчилгээ үзүүлж буй цэг, ажилтнуудын хүртээмжтэй байдал 	Асуумж судалгаа
Үйлчилгээний хүнд сурталгүй, шуурхай байдал	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний шуурхай байдал, - Асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг эрмэлздэг байдал - Тухайн үйлчилгээг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал 	Асуумж судалгаа
Үйлчилгээний чанартай байдал	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал - Ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал - Ажилтнуудын мэргэжлийн ур чадварын хангалттай байдал 	Асуумж судалгаа
Үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал	<ul style="list-style-type: none"> - Хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг байдал - Үйлчилгээг эрх тэгш хүргэх байдал - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад тохиромжтой байдал - Санал гомдол илэрхийлэх боломжтой байдал 	Асуумж судалгаа
Шүүх шинжилгээний байгууллагын сурталчилгаа, олон нийттэй харилцах ажил	<ul style="list-style-type: none"> - Иргэд Шүүх шинжилгээний байгууллагын талаарх мэдээллийг ямар сувгаар авч байгаа, - Шүүх шинжилгээний байгууллагын мэдээллийн нээлттэй илтөд байдал - Иргэдээс шүүх шинжилгээний байгууллагад итгэх, итгэлхандлага нэмэгдсэн байх 	Асуумж судалгаа

Мэдээллийн сан бүрдүүлэлт ба ашиглалт

Асуумж болон ажиглалтын хуудасны мэдээллийг компьютерт шивж оруулан зохих хяналтуудыг хийж, чанарын шаардлагад нийцүүлсний дараа статистик шинжилгээний SPSS 20.0 програмаар боловсруулалт хийлээ. Судалгааны гол индикаторуудын үр дүнг тооцоолох төслийн бүлгүүд, оролцогчдын хүйс, залуучуудын бүлэг, судалгааны талбарууд зэргээс хамаарсан ялгаа байгаа эсэхийг нягталж шинжилсэн. Судалгааны багийнхан тоон судалгааны мэдээллийн боловсруулалтад сонирхож байгаа үзүүлэлтийн дан тоололтоос (frequency analysis) гадна харьцуулсан шинжилгээний арга (cross analysis), дунжийг харьцуулах (means comparison), хувьсагч хоорондын хамаарлыг (correlation analysis) шалгах статистик шинжилгээний аргуудыг ашиглалаа. Тухайлбал, түүврийн бүлгүүдийн статистик шинжүүд хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай эсэхийг дунджуудыг харьцуулах стьюдентийн t-шинжүүрээр шалгасан. Хэрвээ хоёр түүврийн дундаж хоорондоо статистикийн хувьд мэдэгдэхүйц зөрөөтэй байвал t-статистикийн утга нэлээд их (95 хувийн итгэх төвшинд ойролцоогоор ± 2 -оос их) гардаг бөгөөд үүнд харгалзах p-value нь 0 утгад ойр (тухайлбал, 0,05-аас бага) байдаг. Бид тайланд хоёр түүврийн дунжийн 12 ялгааны талаар дүгнэлт хийхдээ дээрх статистикууд ($t=1.2$ ба $p=0.56$)-ыг хаалтад хийж тайлбарласан. Статистик дүгнэлтийг 95 хувийн итгэх төвшинд хийлээ. Мөн чанарын хувьсагчдын хооронд тодорхой мэдэгдэхүйц хамаарал буй эсэхийг хи-квадрат шинжүүрээр үнэлсэн.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Байгууллагын 2023 оны 1-9 дүгээр сарын үндсэн чиг үүргийн статистик мэдээ, инфографик мэдээ, үйл ажиллагааны тайлан, мэдээ, төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөний биелэлтээс харахад үндсэн үйл ажиллагаа болох шинжилгээний чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч нар 2023 оны эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд инженер-техникийн 609, байгалийн ухааны 12800, шүүх анагаах ухааны 31402, криминалистикийн 5764, эдийн засгийн 73, нийт 50648 шинжилгээ хийж дүгнэлт гарган, 23169 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шинжилгээний тоо 3304 буюу 6.1 хувиар буурч, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо 2915 буюу 11.2 хувиар буурсан байна.

Шинжилгээний тоон мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулж, доорх зургаар дүрслэн харуулав.

График 4. Үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байдал

ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ



2023 онд Шүүх шинжилгээний байгууллагын хэмжээнд тус байгууллагын эрх зүйн орчин сайжирч, байгууллагын статус өөрчлөгдөн, шүүхийн шинжилгээний байгууллагын чадамж дээшлэх нөхцөл бүрдсэн жил байв.

Зураг 3. Хуулийн онцлог, шинж байдал



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

“ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН”-Г “ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР” БОЛГОСОН.

01 Лабораторын магадлан итгэмжлүүлэх цахим технологи

01 Инженер техникийн, хөрөнгийн, байгаль орчны, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох зэрэг шинэ төрлийн шинжилгээнүүдийг хийх эрх зүйн орчинг бүрдүүлсэн

01 Албан хаагчдын нийгэм эдийн засаг, эрх зүйн баталгааг дээшлүүлсэн

Олон нийттэй харилцах мэдээлэл сурталчилгааны ажил

Шүүх шинжилгээний байгууллагын олон нийттэй харилцах болон мэдээлэл сурталчилгааны ажлын байдлыг нэг талаас олон нийтийн мэдээллийн хэрэгцээ, хайлтаар тодорхойлж болох бол нөгөө талаас Шүүх шинжилгээний байгууллагын ил тод байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж буй байдлыг харж болно.

Шүүх шинжилгээний байгууллагатай холбоотой мэдээлэл авч буй эх сурвалж

Иргэдийн Шүүх шинжилгээний байгууллагатай холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаар голлон авч байгаа болохыг дараах зургаар дэлгэрүүлэн харууллаа.

График 5. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар



Иргэдийн ихэвчлэн мэдээлэл авахыг хүсэж буй эх сурвалжаар интернет, телевиз гэсэн мэдээллийн эх сурвалжууд нэрлэгдэж байна. Энэ нь мэдээлэл ихэвчлэн авдаг болон авахыг хүсэж буй сувгууд хоорондоо шууд хамааралтай байгааг илтгэж буй тул эдгээр мэдээлэл түгээх эх сурвалжуудыг түлхүү ашиглах нь үр дүнтэй.

Дээрх графикаас харахад иргэд одоогийн нөхцөлд утасны мессеж болон лавлах утсаар мэдээлэл аваад байдаггүй ч цаашид авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн хувь өссөн байна. Мэдээлэл авдаг хэлбэр болон авахыг хүссэн эх сурвалжуудыг үзүүлж буй үйлчилгээ болон байгууллагаар харьцуулахад статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдахгүй байна.


Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгон байгууллагын нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх байдлын хэрэгжилтийг судлав.

“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-аар дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгөхөөр заасан байна.


Зураг 4. Байгууллагын ил тод байдлыг үнэлсэн шалгуур үзүүлэлтийн дүрслэл

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:



Ийнхүү үнэлэхэд Шүүх шинжилгээний ерөнхий газрын мэдээллийн ил тод байдал нь 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 97.46%-ийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Зураг 5. Ил тод байдлын үнэлгээ /shilen.gov.mn/



Эх сурвалж: Shilen.gov.mn цахим сан. 2023.11.08-ны өдөр

Үйлчилгээ авч буй байгууллага болон төрлөөс хамааран мэдээллийн хэрэгцээт байдлыг өөрөөр үнэлж байгаа эсэхэд статистикийн шинжилгээний арга (t-test, anova) ашиглан шалгаж үзэхэд ($F=1.86$; $Sig=0.157$) мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байна.


Шүүх шинжилгээний байгууллагатай холбоотой ямар төрлийн мэдээлэл хэрэгцээтэй байдаг талаарх нийтлэг дурдагдсан хариултын хувилбаруудыг дор харууллаа.

- Шинэ хууль, журмын талаарх мэдээлэл (36 хувь)
- Цахим хуудсаараа дамжуулан үйлчилгээ авахад шаардлагатай мэдээллийг дэлгэрэнгүй байршуулах (22 хувь)
- Шинжилгээний төрөлтэй холбоотой шинэ дүрэм журам, мэдээллийг нийтэд түгээх (17 хувь)
- Шинжилгээний тоон мэдээ мэдээлэл (17 хувь)
- Өргөдөл, гомдол түүний мөрөөр авсан арга хэмжээний талаарх үйл явцын мэдээллийг тогтмол мэдээлэх (6 хувь)
- Нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан гарах лавлагаа, мэдээллийг түгээх (2 хувь) зэргийг дурдсан байна.

Зураг 6. Иргэдэд хэрэгцээтэй мэдээллийн байдал



Зураг 7. Шинжилгээ өгөхөд хариу нь үнэн зөв гарна гэж итгэдэг байдал, хувиар




Үйлчилгээний чанартай байдал

Үйлчилгээний чанартай байдлыг шүүх шинжилгээний байгууллагаас үйлчилгээ авсны дараагаар тухай бүрд нь авсан асуумж судалгааны үр дүнд тулгуурлан шинжилгээ хийсэн. Үйлчилгээний чанартай байдлыг мэдээллийн хангалттай байдал, ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал, мэргэжлийн ур чадварын хангалттай байдал, төлбөр хураамжийн үйлчилгээтэй уялдаатай байдал зэргийг харгалзан үзэж үнэлсэн.

Үйлчилгээ авсан иргэдийн шаардлагатай үйлчилгээгээ авч чадсан эсэхийг нийт судалгаанд хамрагдагчийн хувьд болон үйлчилгээ тус бүрээр харьцуулан харууллаа.

График 6. Шаардлагатай үйлчилгээ үзүүлж чадсан эсэх, хувиар




Нийт судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь шүүх шинжилгээний байгууллага үйлчилгээгээ хангалттай сайн үзүүлж чаддаг гэж, дундажаар 7 хувь нь хангалтгүй муу үйлчилгээ үзүүлдэг гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдагчид одоогийн авч буй үйлчилгээгээ бүрэн авч чадсан эсэхэд дараах байдлаар хариулт өгсөн байна.

17.

График 7. Одоогийн үйлчилгээг бүрэн авч чадсан байдал, хувиар



.....Судалгаанд хамрагдсан иргэдийн 45 орчим хувь нь тухайн үед авсан үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй, дутуу шийдвэрлэгдсэн гэсэн хариултыг өгсөн бол 40 орчим хувь нь тухайн асуудлаа бүрэн шийдвэрлүүлсэн байна.

Авсан үйлчилгээний төрлөөр авч үзвэл шүүх шинжилгээний үйлчилгээнүүд 50-аас дээш хувьтай дутуу шийдвэрлэгдсэн гэж хариулжээ.

Энэхүү үр дүнг шүүх шинжилгээ болон цагдаагийн байгууллагын үйлчилгээ тэр дотроо гэмт хэрэг зөрчилд өртөж хохирсон болон эрхээ хамгаалуулах талаар өргөдөл гаргасан талаарх үйлчилгээ нь нэг удаагийн хандалтаар шийдвэрлэгдэх боломж бага байдагтай холбон тайлбарлаж болно.

Шүүх шинжилгээний байгууллага үйлчилгээний чанартай холбоотой асуудлыг нэгээс таван онооны шкал (1-чанар маш муу; 5-чанар маш сайн)-аар үнэлүүлэхэд дараах үр дүнтэй байна.

Хүснэгт 2. Үйлчилгээний чанартай байдалд өгсөн иргэдийн үнэлгээ, 1-5 онооны дунджаар

Үйлчилгээ төрлөөр	Хариултын дундаж /асуулт бүрээр/					Нийт дундаж
	Ижил тэгш үйлчилсэн эсэх	Эелдэг таатай харилцсан эсэх	Боловсрол, мэдлэг сайн байсан эсэх	Шударга байсан эсэх	Хариуцлагатай байдал сайн байсан эсэх	
Инженер техникийн	4.03	3.97	4.13	4.10	3.90	4.02
Байгалийн ухааны	4.07	4.00	3.80	4.20	3.93	4
Шүүх анагаах ухааны	4.02	3.87	4.18	3.96	4.09	4.04
Криминалистик	4.00	3.70	3.93	3.83	4.10	3.9

Эдийн засгийн	3.88	3.54	4.06	3.93	3.78	3.8
Лавлагаа мэдээлэл	4.10	4.07	4.53	4.30	4.37	4.4
Total	4.00 F=0,784 Sig=0,562	3.8 F=3,543 Sig=0,004	4.12 F=1,796 Sig=0,114	4.01 F=1,165 Sig=0,327	3.98 F=2,479 Sig=0,033	4.00

Sig утга < 0.005-аас бага ; *f* утга > 1 их тохиолдолд авч буй үйлчилгээнээс хамааран ялгаатай хариулт өгч байна гэж үзнэ.

Үйлчилгээний чанарыг үнэлүүлсэн 5-н асуултад дунджаар 4 оноо авч буй нь сэтгэл ханамж сайн байгааг илэрхийлж байна. Тэр дундаа ажилтнуудын боловсрол мэдлэг, хууль хэрэглэг чадвар болон ажилтнуудын үйлчилгээндээ шударга ханддаг эсэхэд 4-өөс дээш онооны дундажтай үнэлгээ өгсөн нь сайн үр дүн харуулж байна.

Үйлчилгээгээр харьцуулж авч үзвэл архивын лавлагаа, мэдээллийн үйлчилгээ авч буй судалгаанд оролцогчид үйлчилгээний чанарт 4,4 буюу харьцангуй өндөр сэтгэл ханамжтай байгаа бол гэмт хэрэг зөрчилд хохирсон, эрхээ хамгаалуулах үйлчилгээ авсан иргэд хамгийн бага онооны дундажтай үйлчилгээний чанарыг үнэлсэн байна.


Авсан үйлчилгээтэй холбогдуулан асуултуудад ялгаатай үнэлгээ өгч буй эсэхийг статистикийн шинжилгээний арга (t-test; anova)-ууд ашиглан шалгаж үзэхэд “ажилтнуудын зөлдөг таатай харилцаа” болон “ажилтнуудын хариуцлагатай байдал” гэсэн асуултуудад үйлчилгээнээс хамааран ялгаатай хариулт өгч байна.

Тухайлбал, “ажилтнуудын зөлдөг таатай байдал”-д өгсөн сэтгэл ханамж архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээ авч буй судалгаанд хамрагдагчийн хувьд өндөр үнэлгээтэй байсан бол гэмт хэрэг, зөрчилд хохирсон болон эрхээ хамгаалуулах хүсэлт гаргасан үйлчлүүлэгчийн хувьд бусад үйлчилгээтэй харьцуулахад бага оноогоор үнэлсэн байна.

Авч буй үйлчилгээтэй холбогдуулан төлбөр, хураамж төлсөн эсэхийг судалгаанд оролцогчоос тодруулахад 60 орчим хувь нь төлбөр хураамж төлөөгүй байна.

Авч байгаа төлбөр, хураамжийг үйлчилгээтэй харьцуулан үнэлсэн үнэлгээг дараах дүрсээр харууллаа.

График 8. Авч буй төлбөр хураамжийг үнэлсэн үнэлгээ



Төлбөр хураамж төлж буй судалгаанд хамрагдагчийн 90 орчим хувь нь үйлчилгээний төлбөрийг “боломжийн” гэж үнэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж дараах байдалтай байна.

Зураг 8. Үйл ажиллагааны чанарын өөрчлөлтийг үнэлсэн байдал



Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны чанарт гарсан өөрчлөлтийг сайжирсан гэж 49 хувь нь буюу оролцогчдын дийлэнх хувь нь үнэлсэн байгаа нь эрх зүйн орчин сайжирч байгууллагын үйл ажиллагаанд эрс өөрчлөлт шинэчлэл бий болж байгааг харуулсан байна.

График 9. Шаардлагатай үйлчилгээ үзүүлж чадсан эсэх, хувиар



Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэртэй холбоотой мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг “сайн” болон “маш сайн” гэж үнэлсэн хувь бусад үзүүлэлтээс илүү хувьтай байна. Харин эсрэгээр төсөв санхүү болон хүний нөөцтэй холбогдолтой мэдээллийн хүртээмжтэй байдлыг “муу” болон “маш муу” гэж үнэлсэн хувь харьцангуй өндөр хувьтай байна. Энэ нь нэг талаас иргэд олон нийт тухайн чиглэлийн холбогдолтой мэдээ, мэдээллийг сонирхох, ач холбогдол өгөх байдал бага байгаатай холбон тайлбарлаж болно. Ялангуяа төсөв санхүүтэй холбогдолтой мэдээллийг судалгаанд хамрагдагчдын дийлэнх буюу 73.8 хувь нь “мэдэхгүй” гэж үзсэн байна.

Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуултуудыг нэгээс таван онооны шкал (1-хүртээмж маш муу; 5-хүртээмж маш сайн)-аар үнэлүүлэхэд дараах үр дүнтэй байна.

Хүснэгт 3. Үйлчилгээний хүртээмжтэй байдлын үнэлгээ, 1-5 онооны дунджаар

№	Асуултууд	Нийт дундаж	Авч буй үйлчилгээний төрлөөс хамаарсан ялгаа байгаа эсэх /Anova test/
1.	Шүүх шинжилгээний байгууллагад ирж үйлчлүүлэхэд хэцүү биш байдал	4.2	F=5,648 Sig=0,000
2.	Ажиллах өдөр/цагийн тохиромжтой байдал	3.6	F=1,747 Sig=0,125

3.	Өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд тохиромжтой байдал	3.0	F=3,129 Sig=0,010
4.	Үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломжтой байдал	3.5	F=1,600 Sig=0,162
5.	Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал	4.5	F=7,646 Sig=0,000
6.	Материал бүрдүүлэлтийн ойлгомжтой байдал	4.7	F=1,404 Sig=0,224
7.	Ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал	3.7	F=1,714 Sig=0,133
Total		3.8	

Sig утга < 0.005-аас бага ; f утга > 1 их тохиолдолд авч буй үйлчилгээнээс хамааран ялгаатай хариулт өгч байна гэж үзнэ.

Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдлын дундаж үнэлгээ 5-аас 3.2 байна. Материал бүрдүүлэлтийн ойлгомжтой байдал болон ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдлыг бусад үзүүлэлтээс бага зэрэг илүү дундажтай үнэлсэн бол үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломжтой байдал болон өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд тохиромжтой байдлыг бусдаас бага дундажтай үнэлжээ. Тэр дундаа үйлчилгээг заавал биечлэн авах бус утас, интернет зэргийг ашиглан хүргэдэг болох нь иргэдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах чухал хүчин зүйл гэдгийг судалгаанд оролцогчид онцолсон.

Үйлчилгээний хүртээмжтэй байдлыг үнэлэхдээ авч буй үйлчилгээний төрлөөс хамааран ялгаатай байдлаар үнэлж буй эсэхийг статистикийн шинжилгээний арга (t-test; anova)-ууд ашиглан шалгаж үзэхэд “биечлэн үйлчилгээ авахад хэцүү биш байдал”, “өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд тохиромжтой байдал”, “үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал” гэсэн асуултуудад эрс ялгаатай хариулт өгчээ. Тухайлбал, биечлэн үйлчилгээ авахад хэцүү биш байдал гэсэн үзүүлэлтэд “гэмт хэрэг зөрчилд өртөж хохирсон, эрхээ хамгаалуулах хүсэлт гаргасан” иргэд харьцангуй бага сэтгэл ханамжтай (2,8 оноо) байна. Мөн үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал гэсэн үзүүлэлтэд энэхүү үйлчилгээг авч буй иргэд бусад үйлчилгээ авч буй бүлгээс бага хувьтай сэтгэл ханамжаа илэрхийлсэн байна.

Үйлчилгээний хүнд сурталгүй шуурхай байдал

Энэ бүлэгт Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээний шуурхай байдал, үйлчилгээний ажилтнуудын асуудлыг шийдвэрлэх хандлага, хүнд суртал зэргийг судалгаанд хамрагдагчдаас авсан анкет судалгааны үр дүнд суурилан гаргалаа.

Шүүх шинжилгээний байгууллагын тусламж хэрэгтэй тохиолдолд иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлнэ гэдэгт итгэж буй байдлыг дараах дүрсээр харууллаа.


Зураг 9. Шаардлагатай тохиолдолд Шүүх шинжилгээний байгууллагын ажилтнууд шуурхай ажиллана гэдэгт итгэдэг байдал, хувиар



Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 53 хувь нь дуудлагын дагуу шуурхай ирнэ гэж итгэдэг болохоо илэрхийлжээ. Харин 5 орчим хувь нь дуудлага өгсөн ч шуурхай ирнэ гэдэгт итгэдэггүй гэсэн хариултыг сонгосон байна. Дуудлагын дагуу түргэн шуурхай үйлчлэх байдалд хариулт өгсөн судалгаанд оролцогчдын хувьд хүйс, Шүүх шинжилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа тоо, авч буй үйлчилгээний төрөл зэргээс хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна.

Одоо авч буй үйлчилгээгээ авахын тулд хэр хугацаа орсон хэдэн ажилтан дамжин үйлчлүүлж байгаа эсэхийг дараах дүрсүүдээр харууллаа.

График 10. Үйлчилгээ авахад зориулж буй хугацаа болон шат дамжлагатай байдал




Судалгаанд хамрагдсан иргэдийн тал хувь нь нэг өдрийн дотор шаардлагатай үйлчилгээгээ авч, асуудлаа шийдүүлж чадаж байгаа бол, 10 орчим хувь нь нэг болон түүнээс дээш өдрийг үйлчилгээ авахад зарцуулж байна.

Ямар үйлчилгээ авахад хамгийн их хугацаа зарцуулж байгааг судалгаанд оролцогчдоос нээлттэй байдлаар тодруулахад судалгаанд хамрагдагчдын 60 орчим хувь нь шинжилгээний хариу удаан, иргэдэд мэдээлэл хангалтгүй өгч байна гэсэн саналыг өгсөн байна.

Үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал

Энэхүү бүлэгт Шүүх шинжилгээний байгууллагатай холбоотой үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал, албан хаагчдын харилцаа, санал гомдол хүлээж авах боломжит байдал зэрэгт шинжилгээ хийсэн.

График 11. Үйлчилгээний чанар, үнэн бодит байдлыг үнэлж буй иргэдийн үнэлгээ, 1 - 5 дунджаар




Судалгаанд хамрагдсан чиглэл дундаас Инженер техник, Шүүх анагаах ухаанаар үйлчлүүлж байгаа иргэд хүний эрхийг хүндэтгэсэн байдлыг хангалттай сайн гэж үзсэн бол эдийн засгийн шинжилгээний чиглэлээр үйлчлүүлж байгаа иргэд хангалтгүй гэж үнэлсэн байна. Энэ нь эдийн засгийн шинжилгээ ачаалал ихтэй, үйлчилгээ авах хугацаа удаашралтай байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 10. Байгууллагын албан хаагч албаны нэрээр далайлган сүрдүүлэх, зүй бус харилцах тохиолдол гарсан уу? Хувиар



Судалгаанд хамрагдсан иргэдийн үнэлгээнээс үзэхэд үйлчлүүлж байгаа иргэд албан хаагч, зүй бус авирлах тохиолдол бараг гараагүй буюу 47 хувь нь адил тэгш үйлчилсэн, 39 хувь нь эелдэг таатай харилцаатай гэж хариулжээ.

График 12. Одоогийн авч байгаа үйлчилгээтэй холбоотой ямар нэгэн санал гомдол байгаа эсэх.



Судалгаанд оролцсон иргэдийн 80.8 хувь нь авч буй үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт байхгүй гэсэн бол, 19.2 хувь нь авч буй үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг нээлттэй байдлаар өгсөн байна. Санал хүсэлтүүдийн 60.8 хувийг шинжилгээний дүгнэлт удаан байна, 13.3 хувийг вэб сайт дээрээ

мэдээллийг түргэн шуурхай, дэлгэрэнгүй байршуулах хэрэгтэй гэсэн саналууд ихэнх хувийг эзэлж байна.

Шүүх шинжилгээний дэлхийн чиг хандлагыг тус байгууллага нь судалж, баримжаалж байгаа нь байгууллагын танилцуулгаас харагдаж байна. Танилцуулгад дурдсан чиг хандлагыг зургаар дүрслэн харуулав.

Зураг 11. Шүүх шинжилгээний үүсэл хөгжил, чиг хандлага



4. 2022 ОНЫ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

“Оюуны цэлмэлт” Төрийн бус байгууллагаас Шүүх шинжилгээний байгууллагын 2022 оны хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ тус байгууллагын чиг үүргийн үнэлгээг оруулж гүйцэтгэж байсан ба тодорхой зөвлөмжийг тайланд тусгасныг дараах байдлаар хэрэгжүүлж ажиллажээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, бүрэн хэрэгжээгүй арга хэмжээг дараа онд төлөвлөн хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байгаа бөгөөд ингэснээр “Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх” урт хугацааны зорилт хэрэгжих суурь үндэс болоход чухал ач холбогдолтой гэж үзсэн байна

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 10 зорилтын хүрээнд 108 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулан ажилласан бөгөөд жилийн эцсийн биелэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу тайлагнаж ажилласан байна.

Зөвлөмж 1-ийн хүрээнд

“ДНХ-ийн нэгдсэн сан бий болгоход шаардлагатай иж бүрэн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж бодис, хэрэгслийг худалдан авна.” арга хэмжээний хүрээнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн дарга бөгөөд нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт холбогдох танилцуулга, саналаа хүргүүлсэн. 2023 оны төсөвт суулгаж шийдвэрлэхээр тохирсон байна.

ДНХ-ийн шинжилгээгээр 2023 оны 10 сарын байдлаар 2 эзэнгүй хэргийг нотлон ажилласан байна.

ДНХ-ийн мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийг хөгжүүлэх, генетик анализаторын аппарат, хэрэгслийг сайжруулах “Генетик мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамж, тоног төхөөрөмжийг шинэчлэх” төслийг боловсруулан Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас 2023 онд хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2” хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/2586 тоот албан бичгийн хамт Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна.

Мөн 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд ДНХ-ийн шинжилгээний лабораторид 400.3 сая төгрөгийн 5 нэр төрлийн тоног төхөөрөмжийг тусгах саналыг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр 01/3423 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлжээ.

Зөвлөмж 2-ын хүрээнд

“БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлнэ.” арга хэмжээний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо”-г шинэчлэн баталсан бөгөөд ажлын хэсэг хуралдаад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр санал өгсөн 3 компаниас сонгон шалгаруулалт үнэлгээ хийж, 2 компанийг шалгаруулж холбогдох бичиг баримтыг БНСУ-ын Экзим банк руу хүргүүлсэн. Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж байна.

2023 онд хийгдсэн ажил БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Шүүх эмнэлгийн шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг барих 1 га газрыг Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт шийдвэрлүүлж, холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрлүүдийг авч барилгын зураг, төсвийг хийлгэсэн байна.

Төслийн зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгарсан “AUM&LEE Architects & Associates” компанитай ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн

дарга П.Сайнзориг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд тус компанийн мэргэжилтнүүд 2023 оны 08 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд ХЗДХЯ-ны холбогдох албан тушаалтнууд, Шүүх шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт хийж, төслийн барилга барих талбай, орчин нөхцөлтэй танилцсан.БНСУ-ын зөвлөх үйлчилгээний тендерт оролцох урилгыг БНСУ-ын талд хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо”-г шинэчлэн баталсан бөгөөд ажлын хэсэг хуралдаад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр санал өгсөн 3 компаниас сонгон шалгаруулалт үнэлгээ хийж, 2 компанийг шалгаруулж холбогдох бичиг баримтыг БНСУ-ын Экзим банк руу хүргүүлжээ.

Зураг төсөл, тендерийн баримт бичиг боловсруулах ажил 8 сарын хугацаанд хийгдэх бөгөөд 2024 оны 05 сард барилгын ажил эхлүүлэхээр төлөвлөгдсөн байна.

Нийслэлийн зүүн талд Шүүх эмнэлгийн цогцос хадгалах барилга барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр БЗД-ийн Засаг даргад 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 02/1391 тоот албан бичиг, нийслэлийн хойд хэсэг Нийслэлийн шүүх шинжилгээний газрын шарил түр хадгалах зориулалттай барилга барих 1 га газрыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн захирагчийн ажлын алба болон газрын албанд 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 03/1795, 03/1849 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн байна.

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА НЬ ӨМНӨХ ЖИЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ТООЦОЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТӨДИЙГҮЙ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЭ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД АМЖИЛТТАЙ ГҮЙЦЭТГЭЖ ИРЖЭЭ.

ЭНЭ УДААГИЙН СУДАЛГААГААР ТУС БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙГ ОРУУЛАЛГҮЙ ЗӨВХӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, ЧАНАРЫГ АВЧ ҮЗСЭНИЙГ ОНЦЛОХ НЬ ЗҮЙТЭЙ.

5. ДҮГНЭЛТ

Байгууллагын үйлчилгээтэй холбоотой гол үзүүлэлтүүдийг 1-5 оноо (1-маш муу, 5-маш сайн)-оор үнэлүүлвэл ерөнхий үнэлгээ нь 4.8 оноо байна.

- Үйлчилгээний чанар - 4.5
- Үйлчилгээний хүртээмжтэй байдал - 4.7
- Үйлчилгээ, мэдээллийн ил тод байдал - 4.9
- Үйлчилгээний шуурхай байдал - 4.9
- Хүний эрх хүндэтгэсэн байдал - 4.9 оноо тус тус байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2023 оны үйл ажиллагааны ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ буюу ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН-г гаргахад НИЙТ ҮНЭЛГЭЭ 96% БУЮУ 4.8 ОНООТой дүгнэгдлээ.

Судалгааны үр дүнгийн задаргааг дараах зургаар харуулав.



- Шүүх шинжилгээний байгууллагаас үйлчилгээ авагчдын хувьд үйлчилгээндээ хүний эрхийг дээдэлсэн байдлыг хамгийн өндөр онооны дундажтай үнэлсэн бол, үйлчилгээний чанартай байдлыг хамгийн бага оноогоор үнэлсэн байна.
- Байгууллагатай холбоотой мэдээллийг иргэд ихэвчлэн интернет, телевиз гэсэн эх сурвалжаас авч байна. Цаашид эдгээр мэдээллийн эх сурвалжаас мэдээ, мэдээлэл авахаас гадна лавлах утас, утасны мессеж гэсэн эх сурвалжаар мэдээллийг түлхүү авах сонирхолтой байна.
- Иргэд гол төлөв байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээллийг голчлон сонирхож, мэдээлэл авч байна. Харин төсөв санхүү, хүний нөөцтэй холбогдолтой мэдээлэлд төдийлөн ач холбогдол өгөхгүй, мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

- Иргэд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим эх сурвалжаас эрэлхийлэхдээ цахим хуудсаас гадна албан ёсны фэйсбүүк хуудсыг ашиглах байдал ихэссэн байна.
- Шүүх шинжилгээний байгууллагатай холбоотой мэдээллүүдээс “шинэ хууль журам, зохицуулалт”-тай холбоотой, “үйлчилгээ авахад шаардлагатай баримт бичиг, бүрдүүлэх материал”-тай холбоотой мэдээлэл ихэвчлэн иргэдэд хэрэгцээтэй байна.
- Иргэдийн шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдад итгэх итгэл, хандлага өндөр байна.
- Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээний чанарыг талаас илүү хувь нь хангалттай сайн гэж үнэлжээ.
- Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээ болон авч байгаа төлбөр хураамжийн уялдаатай байдлыг боломжийн гэж ихэнх судалгаанд оролцогчид үнэлсэн байна.
- Үйлчилгээний хүртээмжтэй байдалтай холбогдуулан иргэд холбогдох үйлчилгээг лавлах утас, интернет, төрийн үйлчилгээний ТҮЦ машин ашиглан авах сонирхол ихтэй байна. Харин ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал, ажиллах цагийн хуваарь, материал бүрдүүлэлтийн ойлгомжтой байдал зэрэг нь сайн үзүүлэлттэй байна.
- Үйлчилгээний шуурхай байдал лавлагаа мэдээлэл олгох зэрэг нь бусад үйлчилгээтэй харьцуулахад түргэн шуурхай байна.

6.САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Шүүх шинжилгээний байгууллага нь мэдээ, мэдээллийг түгээхдээ телевиз, интернет гэсэн түгээмэл мэдээллийн эх сурвалжийг ашиглахаас гадна лавлах утсыг тогтмол байнгын ажиллагаатай ажиллуулах, гар утасны мессежийн үйлчилгээ ашиглах зэргээр мэдээлэл өгөх нь иргэд, олон нийтийн хүлээлтийг хангахаар байна. Мөн интернет эх сурвалж ашиглахдаа зөвхөн вебсайтаас гэлтгүй фэйсбүүк хуудас, гар утасны аппликейшн зэргийг ашиглах нь хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг татах үр дүнтэй арга болж болох юм.
- Үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой шинэ дүрэм журам, тогтоол шийдвэрүүдийг тухай бүрд нь нийтэд мэдээлэх, үйлчилгээ авахад шаардагдах баримт бичгүүдийг ил тод болгох нь иргэд олон нийтэд хэрэгцээтэй байна.
- Шүүх шинжилгээний байгууллага албан ёсны цахим хуудсандаа оруулж буй мэдээллийнхээ эх сурвалж (мэдээлэл оруулсан этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл), мэдээллийн цаг үеийн байдал хуулийн хугацаанд мэдээлэл оруулж буй эсэх)-ыг сайжруулах шаардлагатай байна.
- Иргэдийн байгууллагаас шаардлагатай үйлчилгээгээ авахад зарцуулдаг хоног болон хандалтын тоо бусад төрийн байгууллагатай харьцуулахад их байна. Иймд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх шат дамжлагыг багасгах, энгийн хялбар байдлаар үйлчилгээ үзүүлэхэд анхаарах хэрэгтэй юм.
- Ажилтнуудын шударга байдал, хууль хэрэглэх чадварыг үйлчлүүлэгчид өндрөөр үнэлж байгаа учир ажилтнуудыг чадваржуулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаагаа бататгах, хадгалж үлдэх нь чухал байна.

- Зарим төрлийн үйлчилгээг ТҮЦ машин, emongolia-аар өгч байгаад үйлчлүүлэгчид сайшаалтай хандаж байгаа бөгөөд олон нийтэд мэдээллийг өргөн хүрээтэй өгөх, үйлчилгээний хүрээг өргөсгөж, байгууллагаас өгдөг лавлагаа мэдээллийг бүрэн хамруулах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.
- Шинжилгээг давтан дахин хийх нь хэрэглэгч болон иргэдэд цаг хугацаа алдах, зардал чирэгдэл учрах, улмаар цагдан хоригдож байгаа сэжигтэн яллагдагчийн эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсэхээр байна. Шинжээчийн дүгнэлтийг давтан хийсэн үед, анхны дүгнэлтээс зөрж гарсан тохиолдлыг судлах, мэргэжлийн зүгээс дүн шинжилгээ хийж учир холбогдлыг нь тогтоож ажиллах шаардлагатай.
- Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтсийн иргэдийн хүлээлгийн хэсгийг сайжруулах болон тулгуур эрхтэний гэмтэлтэй иргэдийг тэргэнцэрээр тосч үйлчлэх түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчлэх асуудлыг цаашид судлах хэрэгтэй.
- Албан хаагчдын судалгааг <https://forms.gle/wqu9Wj9LrH9qgSti9> google doc-оор авч үр дүнг гаргахад дараах саналуудыг дэвшүүлсэн тул Шүүх шинжилгээний байгууллагын удирдлагууд анхаарч ажиллах нь зүйтэй.
 - Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах;
 - Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, шаардлагатай орон тоог нэмэгдүүлэхэд анхаарч, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх;
 - Хүний нөөцийн томилгоог оновчтой хийж, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах;
 - Газар, хэлтсийн уялдаа холбоог сайжруулах, нэгжүүдийн ажлын онцлогийг бусад албан хаагчдад таниулах, ойлгуулах ажлыг зохион байгуулах;
 - Удирдах албан тушаалтнууд орчин үеийн удирдлагын арга барилаас суралцах;
 - Хөдөө орон нутагт хэлтсийн жолооч нарыг жижүүрийн хуваарьт оруулах, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх;
 - Дүрэмт хувцасны хангалт, чанарыг сайжруулах;
 - Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах;
 - Албан хаагчдыг сурч боловсроход анхаарч, урт богино хугацааны сургалтад хамруулах;
 - Албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, томилолт, цогцос шинжилгээнд орсон мөнгийг тухай бүр олгодог байх.

Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын хэрэгжилтийн талаарх үнэлгээний хуудас

Эрхэм оролцогч Танаа!

Та санал асуулгад үнэн зөв хариулснаар Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт үйл ажиллагааг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

1. Таны хувийн мэдээлэл

Таны нас:, хүйс: эр, эм /зурна уу/

Таны боловсрол:

- бага дунд тусгай дунд дээд Бусад

Таны албан тушаал:

Та ШШЕГ-т хэдэн жил ажиллаж байна вэ?

<input type="radio"/> 1 жил хүртэл	<input type="radio"/> 2-5 жил	<input type="radio"/> 6-10 жил	<input type="radio"/> 11-15 жил	<input type="radio"/> 16-20 жил	<input type="radio"/> 20-25 жил	<input type="radio"/> 26-аас дээш жил
------------------------------------	-------------------------------	--------------------------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------------

Та Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд ажиллах болсон шалтгаанаа сонгоно уу.

- А. Томилогдсон
 Б. Өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа
 В. Олон жил ажилласан болохоор
 Г. Цагдаагийн ерөнхий газрын шийдвэрээр түр хугацаанд ажлын байр сэлгэн ажиллаж байгаа
 Д. Түр хугацаанд хүний оронд ажиллаж байгаа
 Е. Бусад

2. Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийн талаарх таны үнэлгээ. 1-3 баллаар үнэлнэ үү.

(1-муу буюу хангалтгүй, 2-дунд зэрэг, 3 сайн буюу хангалттай)

№	Үнэлгээ өгөх үзүүлэлт	Оноо			Бусад /тайлбар, эсхүл мэдэхгүй гм/
1	Үйлчилгээний орчин				
	Үйл ажиллагаа явуулах зориулалтын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, нөхцөл, боломж	1	2	3	
	Хүлээлгийн танхимын ая тухтай байдал /сандлын хүрэлцээ, сонин, сэтгүүл гм/	1	2	3	
	Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ	1	2	3	
	Дулаан, агааржуулалт, гэрэлтүүлгийн байдал	1	2	3	
	Бие засах газрын ариун цэвэр, үйлчилгээний байдал	1	2	3	
	Мэдээллийн хүртээмж /мэдээллийн самбар, тараах материал, гарын авлага, зөвлөмжийн хүрэлцээ гм/	1	2	3	
	Зарим үйлчилгээг өөрөө өөртөө үйлчлэх хэлбэрээр /ТҮЦ машин гм/ авах боломж	1	2	3	
	Интернет орчины хүрэлцээ, хурд	1	2	3	
	Дотоод сүлжээний ажиллагаа	1	2	3	

Алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин, нөхцөл				
Орон байрны хангамж, хүрэлцээ	1	2	3	
Цалин хөлс олголт, хүртээмж	1	2	3	
Шагнал урамшууллын байдал, ил тод байдал	1	2	3	
Нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдах боломж /даатгал, банкны зээл, тэтгэмж тусламж гм/	1	2	3	
Дүрэмт хувцас, бусад хэрэглэлийн хангалт, чанар, хүртээмж	1	2	3	
Хоол хүнсний хангалт, чанар, хүртээмжтэй байдал /нэр төрөл/	1	2	3	
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж, нөхцөл	1	2	3	
Сурах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх боломж, нөхцөл	1	2	3	
Чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл /фитнесс, төрөл бүрийн сургалт, соёл урлагийн үйлчилгээ, номын сан гм/	1	2	3	
Шинэ санаа, бүтээл гаргах боломж нөхцөл, дэмжлэгт байдал	1	2	3	
Тодорхой хугацаанд сайн ажилласан, туршлага хуримтлуулсан нөхцөлд тухайн чиглэлээр албан тушаал ахих, цол нэмэх боломж	1	2	3	
Үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал хүсэлт гаргах, шаардлага тавьж, шийдвэрлүүлэх боломж, нөхцөл	1	2	3	

3. Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт мөрдөгдөх хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг ерөнхийд нь хэрхэн үнэлж байна вэ?

- 5 буюу маш сайн
 4 буюу сайн
 3 буюу дунд зэрэг
 2 буюу тааруу
 1 буюу хангалтгүй
 мэдэхгүй

4. Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын нэгжүүдийн ажлын уялдаа холбоо, хамтран ажиллах байдлыг үнэлнэ үү.

- 5 буюу маш сайн
 4 буюу сайн
 3 буюу дунд зэрэг
 2 буюу тааруу
 1 буюу хангалтгүй
 Мэдэхгүй

5. Таныг ажил үүргээ гүйцэтгэсний төлөө иргэд, үйлчлүүлэгчдээс бэлэг сэлт, шан харамж санал болгодог уу?

- Тийм
 Үгүй
 Хариулахыг хүсэхгүй байна.

6. Шүүхийн шинжилгээний ерөнхий газрыг одоо байгаагаас нь сайжруулахад ямар арга хэмжээг авах хэрэгтэй гэж та үзэж байна вэ? Хамгийн чухал гэж үзсэн 3-4 арга хэмжээг дараалуулан бичнэ үү.

1.
2.
3.
4.

Санал асуулгад идэвхитэй оролцсон танд баярлалаа.Т
анд ажлын амжилт хүсье. ☺

**НЭГ.ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНД
СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ БАЙДАЛ**

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.	Та хэдэн настай вэ?	Нас [. . .]
2.	Таны хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3.	Таны албан боловсролын дээд түвшин ямар вэ? (Ж/нь дээд сургууль төгссөн хүн “Дээд” гэж хариулах)	1. Боловсролгүй 2. Бага /3/4 анги/ 3. Суурь /8/9 анги/ 4. Бүрэн дунд /10/11/12 анги/ 5. Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ) 6. Тусгай мэргэжлийн дунд (коллеж) 7. Дээд
4.	Таны ажил эрхэлдэг салбар	1. Ажилгүй 2. Төрийн байгууллага 3. Төрийн бус байгууллага 4. Олон улсын байгууллага 5. Хувийн хэвшил, компани 6. Хувиараа бизнес эрхэлдэг 7. Бусад.....

5. Шүүх шинжилгээний байгууллага танд шаардлагатай үйлчилгээг үзүүлж чадсан уу?

1. Хангалттай сайн үзүүлдэг
2. Дунд зэрэг үйлчилгээ үзүүлдэг
3. Хангалтгүй муу байдаг
4. Сайн мэдэхгүй байна

6. Таны одоогийн авч буй үйлчилгээ бүрэн шийдвэрлэгдэж чадсан уу?

1. Бүрэн шийдвэрлэгдсэн
2. Хагас дутуу шийдвэрлэгдсэн. Шалтгаан:

.....
.....

3. Огт шийдвэрлэгдээгүй. Шалтгаан:

.....
.....

7. Одоогийн үйлчилгээгээ авахын тулд хэр хугацаа орсон бэ?

1. _____ цагийн дотор
2. _____ хоногийн дотор
3. Хэрэв шийдэгдээгүй бол үйлчилгээ авахаар анх хандсан хугацаа: _____

8. Үйлчилгээний хүртээмжтэй байдалтай холбоотой дараах асуултуудыг үнэлнэ үү?

№	Үнэлэх үзүүлэлтүүд	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	Мэдэ хгүй
1.	Шүүх шинжилгээний байгууллагаар үйлчлүүлэхэд хэр хэцүү байна вэ?	1	2	3	4	5	0
2.	Ажиллах өдөр/цаг нь танд хэр тохиромжтой байдаг вэ?	1	2	3	4	5	0
3.	Өндөр настан/хөгжлийн бэрхшээлтэй иргэд энд үйлчлүүлэхэд хэр тохиромжтой байна вэ?	1	2	3	4	5	0
4.	Тус үйлчилгээг утас, интернет, ТҮЦ машин ашиглан авах боломж байсан уу?	1	2	3	4	5	0
5.	Авч буй үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай байсан уу?	1	2	3	4	5	0

6.	Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байсан уу?	1	2	3	4	5	0
7.	Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байсан уу?	1	2	3	4	5	0

9. Та байгууллагын үйлчилгээний чанартай холбоотой дараах үзүүлэлтэд харгалзах үнэлгээг өгнө үү?

№	Үнэлэх үзүүлэлтүүд	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
1	Танд бусадтай адил ижил тэгш үйлчилсэн үү?	1	2	3	4	5	0
2	Тантай эелдэг таатай харилцсан уу?	1	2	3	4	5	0
3	Ажилтны боловсрол, мэдлэг ямар байсан бэ?	5	4	3	2	1	0
4	Ажилтны шударга байдал ямар байсан бэ?	5	4	3	2	1	0
5	Ажилтны хариуцлагатай байдал ямар байсан бэ?	5	4	3	2	1	0

10. Одоогийн авч буй үйлчилгээгээр үйлчлүүлэхдээ мөнгө төлсөн үү? Тийм бол ямар зориулалтаар мөнгө төлсөн бэ?

1. Үйлчилгээний төлбөр (Үйлчилгээ үзүүлсний төлөө төлсөн төлбөр)
2. Төлбөр, хураамж төлөх зорилгоор (бичиг баримтын татвар, мөнгөн хураамж)
3. Бусад.....
4. Төлж байгаагүй.

11. Хэрэв ямар нэгэн төлбөр хураамж төлсөн бол авсан үйлчилгээтэй харьцуулахад хэр боломжийн байсан бэ?

1. Их
2. Боломжийн
3. Бага

12. Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч нь танд үйлчилгээ үзүүлэхдээ албаны нэрээр далайлган сүрдүүлэх, зүй бус харилцах тохиолдол гарсан уу?

1. Тийм
2. Үгүй

13. Одоогийн авч байгаа үйлчилгээтэй холбоотой ямар нэгэн санал гомдол байгаа эсэх?

1. Тийм. Ямар
-

2. Үгүй

14. Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд хэдэн ажилтанд хандсан бэ? [.]

15. Та хүссэн үйлчилгээгээ авахын тулд нэг ажилтанд олон удаа хандах тохиолдол гарсан уу?

1. Тийм. /хэрэв тийм бол хэдэн удаа, яагаад?/
-

2. Үгүй

16. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хууль хэрэглэх чадварыг үнэлнэ үү?

1. Маш сайн
2. Сайн
3. Дунд
4. Муу
5. Маш муу

